

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


.....Б.МӨНХБАТ

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН
ГУТЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР
/...6.....ХУУДАС /

ТАНИЛЦСАН:



Д.МЯНГАНБААТАР
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Ц.ОДХҮҮ
СТРАТЕГИ, САНХҮҮ
БОРЛУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

ХЯНАСАН:



Г.АЛТАНТУЯА
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:



Г.УЯНГА
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АЖЛЫН ГУТЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

1. Тендерийн сонгон шалгаруулалтад оролцох дараах нэр бүхий тусгай зориулалтын ажлын гутлыг нийлүүлнэ. Үүнд:
 - Ажлын зуны гутал
 - Ажлын өвлийн гутал
 - Ажлын шаахай
2. 2025 онд шаардлагатай тусгай зориулалтын ажлын гутлын тоог дараах хүснэгтээр харуулав. /Хүснэгт 1/
3. Тусгай зориулалтын ажлын гутлыг өвөл, зуны гутал гэж ангилах ба ажлын зуны гутал, шаахайг 2025 оны 04 сарын 15-ны дотор, ажлын өвлийн гутлыг 2025 оны 09 сарын 15-ны дотор тус тус нийлүүлнэ.

Ажлын гутлын нэр төрөл, тоо хэмжээ

Хүснэгт 1

Бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ /ширхэг/	Ангилал
Ажлын зуны гутал	371	Тусгай зориулалтын ажлын гутал
Ажлын өвлийн гутал /нэхий дотор, эсгий улавч/	123	
Ажлын өвлийн гутал /үстэй дотор, үстэй улавч/	261	
Ажлын шаахай	86	

Нэг. Тусгай зориулалтын ажлын гутал нийлүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

- 1.1 Ажлын гутал нь MNS 5623:2006 стандартын шаардлагыг хангасан байна.
- 1.2 Ажил гүйцэтгэх үед болзошгүй бэртэл гэмтлээс хамгаалах, ажлын орчин нөхцөлд тохирсон, хөлд эвтэйхэн, ул зузаан, чийг татдаггүй, халтирдаггүй хүйтэнд тэсвэртэй, цахилгаан гүйдэл дамжуулдаггүй, ус, тос, төрөл бүрийн химийн бодис, шүлтлэг орчинд ажиллахад шаардлага хангасан байна.
- 1.3 Ажлын гутал нь хөлийн анатомийн бүтцэд нийцсэн өмсөхөд хөлд эвтэйхэн хэвтэй байна.
- 1.4 Хуруу, шагайн хамгаалалттай, 200 Дж хүртэлх хэмжээний цохилтын хүчийг даах тэсвэртэй байна.
- 1.5 Зуузайны хамгаалалттай, шагайны хэсгийг хамгаалсан нэмэлт зөөлөвчтэй байна.

- 1.6 Ул болон ар хэсэг нь механик биетээс хамгаалах хамгаалалттай байна.
- 1.7 Ул нь цөмрөхгүй, суулт өгөхгүй байна.
- 1.8 Уландаа хурц зүйл нэвтрэхээс хамгаалсан кевлар давхаргатай.
- 1.9 Өнгө үзэмжтэй, бат бөх, давхар оёдолтой, хурууны хамгаалалттай, хүний арьсанд хүрэх хэсгүүд нь зөөлөн материалаар хийгдсэн байна.
- 1.10 Тос, ус чийг, тоос шороо, химийн бодис болон шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй байна.
- 1.11 Ажлын шаахай нь халтирдаггүй зөөлөн ултай, чийг татдаггүй материалаар хийгдсэн, өндөр өсгийгүй байна.
- 1.12 Улирлын нөхцөл байдлаас хамааруулан өвөл, зуны гуталд дараах хамгаалалтын тэмдэглэгээ байх шаардлагатай. Үүнд:
- C/75, I/75 - цохилт ба даралтанд тэсвэртэй байна.
 - CT - нийлмэл хамрын хатуулгатай, хөнгөн материалаар хийгдсэн байна.
 - INS – хүйтнээс хамгаалагдсан, хүйтэн орчинд ажиллахад зориулагдсан байна.
 - MG - гадны гэмтэл, цохилт, элдэв нөлөөллөөс хамгаалсан хамгаалалттай.
 - NM - 100% металл тоноглолгүй, даралт, цохилт, цахилгаанд тэсвэртэй материалуудыг ашигласан байна.
 - OR - тосны хамгаалалттай, тостой орчинд ажиллахад тохиромжтой байна.
 - SD - гутал хийсэн материал нь цахилгаан орны нөлөөгөөр цэнэгждэггүй байна.
 - SR – гутлын улны материал нь гадаргуу дээр хальтирдаггүй байна.
- 1.13 Гутал нь чанарын үзүүлэлтийг үзүүлсэн үйлдвэрлэгчийн шошго тэмдэгтэй байна. Шошгод үйлдвэрлэсэн үйлдвэрлэгч, хийгдсэн материал, цахилгаанаас тусгаарладаг эсэх зэргийг тодорхой бичсэн байна.
- 1.14 Үйлдвэрлэгчийн шошго нь Англи хэл дээр байж болох ба Хятад хэл дээр байвал шошгыг заавал Монгол хэл рүү орчуулж хавсаргасан байна.

Хоёр. Ажлын зуны гутлын шаардлага

- 2.1 Ажлын зуны гутал нь хагас түрийтэй үдээстэй байна. Түрийний өндөр нь гутлын улнаас дээш ойролцоогоор 12 см -15 см байна.
- 2.2 Дулааны улиралд өмсөхөд тохиромжтой, чийг татахгүй байна.

2.3 Өлмий хэсэг ойролцоогоор 2.5 см, өсгий хэсэгт ойролцоогоор 4 см зузаантай, халтирахгүй, арзгар үргэлж ултай байна.

2.4 Үртэс, тоос шороо орохооргүй эх биетэйгээ үргэлж хэлтэй байна.

Зураг1. Тусгай зориулалтын ажлын зуны гутлын жишиг зураг



Гурав. Ажлын өвлийн гутлын шаардлага

3.1 Өвлийн ажлын гутал нь 2 төрлийн жишиг загвартай байна.

- Жишиг загвар 1. Урт түрийтэй, үдээстэй, үстэй дотортой, үслэг улавчтай байна. Түрийний өндөр нь гутлын улнаас дээш ойролцоогоор 25 см-30 см байна. /Зураг 2/
- Жишиг загвар 2. Урт түрийтэй, үдээсгүй шууд угладаг, нэхий дотортой, эсгий улавчтай байна. Түрийний өндөр нь гутлын улнаас дээш ойролцоогоор 30 см-35 см байна. /Зураг 3/

3.2 Өвлийн гутал нь хүйтний улиралд өмсөхөд зориулагдсан, цас чийгэнд тэсвэртэй, арьсан материалтай, хөлддөггүй, нэхий дотортой, эсгий улавчтай байна.

3.3 Зузаан, халтирахгүй, хөлддөггүй арзгар үргэлж ултай байна.

3.4 Өлмий хэсэгт ойролцоогоор 3 см, өсгий хэсэгт ойролцоогоор 5 см зузаан ултай байна.

3.5 Цас, шороо орохооргүй эх биетэйгээ үргэлж хэлтэй байна.

3.6 Хөдөлгөөнд саадгүй түрийн зохион байгуулалттай байна.

Зураг 2. Тусгай зориулалтын ажлын өвлийн гутлын жишиг зураг



Зураг 3. Тусгай зориулалтын ажлын өвлийн гутлын жишиг зураг



Дөрөв. Ажлын шаахай

- 4.1 Халтирдаггүй, дуу чимээ гаргахгүй зөөлөн үргэлж ултай байна.
- 4.2 Чийг татдаггүй материалаар хийгдсэн байна.
- 4.3 Өндөр өсгийгүй байна.
- 4.4 Улавч нь нумтай байна.
- 4.5 Агаар нэвтрүүлдэг байна.
- 4.6 Ар талдаа урагшаа хойшоо болдог оломтой байна.



Зураг 3. Ажлын шаахайн жишиг зураг

Тав. Баглаа, боодолд тавигдах шаардлага

- 5.1 Ажлын гутлыг хосоор нь, размер тус бүрээр нь багцалж хайрцаглана.
- 5.2 Нийлүүлэгч компани нь бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, огноог бичсэн дагалдах хуудастай байна. Дагалдах хуудсыг 2 хувь бичиж 1 хувийг захиалагч талд өгнө.
- 5.3 Хайрцагны хажуу талд ус, чийгээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.